

GOETHE MUSIKLABOR ULAN BATOR

Жазз хөгжим Монгол улсад: Гёте-Институт нь
Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим төслийг
2014 оноос хойш Хөгжим Бүжгийн Коллежид хэрэгжүүлэн,
жазз хөгжимчдийн залуу үе халааг сургахад дэмжлэг үзүүлж байна.



**GOETHE
INSTITUT**

Sprache. Kultur. Deutschland.



**GOETHE MUSIKLABOR
ULAN BATOR**



Goethe Musiklabor Ulan Bator

Монгол улс бүхий л талаараа өөрчлөгдөн хөгжиж байна. 1990 оны ардчилсан хувьсгалын дараагаас тус улсад барууны соёл нэвтрэх болжээ. Хэдий жижиг зах зээлтэй боловч поп, рок, хип-хоп, жазз зэрэг хөгжмийн салбарууд **эрчтэйгээр хөгжиж** байна. Нөгөө талаар, уламжлалт боловсролын байгууллагууд энэхүү хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж чадахгүйд хүрээд байв.

Тиймээс сонгодог болон үндэсний хөгжмийн боловсрол олгодог чухал төлөөлөгчдийн нэг болох **Хөгжим Бүжгийн Коллежтой** хамтран Гёте-Институтийн Монгол дахь төлөөлөгчийн газар нь 2014 оны 9-р сард Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим (GMUB)-ыг үүсгэн байгуулсан юм.

Герман улсын басс хөгжимчин Мартин Зенкерийн удирдлага дор хэрэгжиж буй GMUB төслөөр Монгол улсад жазз болон орчин үеийн хөгжмийн боловсролыг олгох үндэс суурь тавигдсан. Төсөл хэрэгжиж эхлээд дөнгөж хоёр жил өнгөрсөн боловч тус сургалтыг Хөгжим Бүжгийн Коллежид **бакалаврын төвшинд** заахаар болоод байна.

Тусгайлан барьж тохижуулсан хоёр анги танхимд Монголын залуу халаа болсон хөгжимчид олон хоолойн ухаан, соноршуулга, хөгжмийн түүх, хөгжимдөх урлаг зэрэгт суралцан мэргэших юм. Эдгээр анги танхимуудыг **өндөр чанар бүхий хөгжмийн** зэмсэг, тоног төхөөрөмжүүдээр тохижуулсан бөгөөд Герман улсаас нэг тонн орчим эд материалыг тээвэрлэн авчирсан байна.

Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхимын сургалт нь Герман, Австри, Франц, Их Британи, Канад, АНУ болон бусад орноос хүрэлцэн ирэх **зочин багш** нарын хичээлүүдээр баяждаг бөгөөд тэдгээр багш нар цөөн хоногт эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулах буюу олон долоо хоногийн турш GMUB-д хичээл заадаг. Өнөөг хүртэл нийтдээ 50 орчим зочин багш Улаанбаатар хотноо хүрэлцэн ирсэн байна.

Ингэснээр сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд GMUB нь Монгол улсын жазз хөгжмийн салбарын **чухал төв** болон хөгжиж харилцаа холбоог бэхжүүлэн ажиллаж байна.



ENJI: Mongolian Song

Тус цомог бий болсон нь Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхимын үүсэл хөгжил, барууны жазз хөгжимчид болоод монгол авьяастнуудын нягт хамтын ажиллагаатай салшгүй холбоотой. Дуучин Эрхэмбаярын Энхжаргал нь GMUB-д анхлан суралцагчдын нэг юм.

Тус төслийг хэрэгжүүлж буй Хөгжим Бүжгийн Коллеж нь Монголын томоохон хөгжмийн зохиолчдын нэг, орчин цагийн хөгжмийг үндэслэгч гэгдэх С. Гончигсумлаагаар овоглогдсон юм.

Хөгжмийн зохиолч С. Гончигсумлаа агсны нэрээр нэрлэгдсэн энэхүү төслийг Мартин Зенкер 2015 онд буюу хөгжмийн зохиолчийн зуун насны ойгоор хэрэгжүүлж эхэлсэн

бөгөөд тус төслөөр Монголын уламжлалт хөгжмийг орчин үеийн жазз хөгжимтэй хослуулан, тус бүрийн онцлог шинжийг агуулсан хөгжмийн урсгалыг бий болгохыг зорьж байна.

Тогтооход хялбар байдаг онцлог шинжтэй монгол хөгжмийн аялгууг жазз хэв маягт оруулан шинээр найруулж, ардын уламжлалт дуунд төдийлөн ажиглагддаггүй хэмнэл бүхий элементийг оруулж өгдөг. Харин дуулах явцад монгол хэв маяг түлхүү илэрдэг.

Хөгжмийн энэхүү хоршилд тус цомгийн өвөрмөц чанар оршиж буй агаад тус бүтээл нь олон орны хөгжимчдийн хамтын ажлын үр дүн юм.



The Jazz Train


The Jazz Train хамтлаг нь 2016 оны 9-р сард үүсгэн байгуулагдсан бөгөөд Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим буюу GMUB төслөөс төрөн гарсан.

Хоёр жилийн хугацаанд тус хамтлагийн хөгжимчид нь олон улс орноос хүрэлцэн ирсэн багш нарын удирдлага дор GMUB-д суралцсан юм.

Олон улсын жазз хөгжмийн өдрөөр энэхүү хамтлаг нь өөрсдийн хамгийн анхны бие даасан цомгийг The Jazz Train нэртэйгээр гаргасан.

The Jazz Train хамтлагийн бүрэлдэхүүнд:

Г. Хонгор, нарийн бүрээ
Б. Мөнхтэмүүлэн, саксофон
Э. Шүтээн, төгөлдөр хуур
Ц. Мөнгөтовч, басс
Б. Хүслэн, бөмбөр



International Jazz Series

Гёте-Институт болон JazzLab агентлаг нь олон улсын жазз цуврал тоглолтыг зохион байгуулж дэлхийд танигдсан жазз уран бүтээлчдийг Улаанбаатар хотноо урьж байна.

Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхимын оюутнууд тэдгээр уран бүтээлчидтэй хамтран Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын тайзнаа тоглолтоо хийдэг.

JazzLab нь Монгол улс дахь цорын ганц бөгөөд хамгийн анхны жазз хөгжмийн агентлаг юм. Тус агентлаг нь олон улсын уран бүтээлчидтэй хамтран ажиллаж Улаанбаатар хотод жазз хөгжмийг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг болно.

2016-2017 онд зохиогдох тоглолтууд:

Kenny Washington (АНУ), 2016.10 сар
Champion Fulton (АНУ), 2016.12 сар
Ignasi Terraza (Испани), 2017.02 сар
Laurent Maur (Франц), 2017.03 сар
Jesse Davis (АНУ), 2017.07 сар



Холбоо барих:

Михаэль Хайнст

Монгол дахь Гёте-Институтийн захирал
Улаанбаатар дахь төлөөлөгчийн газар
michael.heinst@ulanbator.goethe.org

Мартин Зенкер

Төслийн зөвлөх
Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим
info@martinzenker.com

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.goethe.de/mongolei
www.facebook.com/goethemusic